

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/040/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025.02.03	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576	Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
	Ахлах аудитор Утас: 88761199	Н.Батчимэг Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn
	Аудитор Утас: 88953144	Д.Даваадорж Цахим хаяг: davaadorjd@audit.gov.mn
	Цахим хуудас: www.audit.mn	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	144
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	188
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	188
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	188
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУЕП	Монгол Улсын Ерөнхий Прокурор



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025. 02. 12 № 2/08

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

5020131

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Шатахуун зарцуулалтыг тооцохдоо Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан шатахуун зарцуулалтын норматив баримтлаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>56,553,350.00</u>	<u>74,024,263.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,142,700.00	2,000,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,142,700.00	2,000,000.00
3121	Төгрөг	2,142,700.00	2,000,000.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	2,000,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	2,142,700.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	54,410,650.00	72,024,263.00
351	Түүхий эд материал	00.00	00.00
354	Хангамжийн материал	54,410,650.00	72,024,263.00
35410	Бичиг хэргийн материал	3,861,900.00	3,480,900.00
35420	Аж ахуйн материал	36,909,950.00	37,631,450.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,447,000.00	4,641,000.00
35470	Бусад хангамжийн материал	12,191,800.00	26,270,913.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,377,035,531.55</u>	<u>3,481,746,519.64</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,377,035,531.55	3,481,746,519.64
392	Биет хөрөнгө	3,325,961,131.55	3,430,088,786.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,158,932,197.00	3,158,932,197.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-46,810,861.01	-99,526,397.69
39203	Авто-тээврийн хэрэгсэл	118,709,485.21	319,909,485.21
39204	Хуримтлагдсан элэгдэл	-44,418,977.63	-78,874,725.14
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	157,710,772.91	161,555,310.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	-82,789,639.40	-91,373,644.11
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	98,986,076.96	96,577,993.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	-34,357,922.49	-37,111,433.70
393	Биет бус хөрөнгө	51,074,400.00	51,657,733.36
39301	Програм хангамж	400,000.00	700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-400,000.00	-116,666.64
39303	Бусад биет бус хөрөнгө	51,074,400.00	51,074,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,433,588,881.55</u>	<u>3,555,770,782.64</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,142,700.00</u>	<u>2,000,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,142,700.00	2,000,000.00
414	Урьдчилж орсон орлого	2,142,700.00	2,000,000.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	2,142,700.00	2,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,431,446,181.55</u>	<u>3,553,770,782.64</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,431,446,181.55	3,553,770,782.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	439,978,322.12	439,978,322.12
51101	Өмч: - төрийн	439,978,322.12	439,978,322.12
512	Хуримтлагдсан үр дүн	2,779,012,579.35	2,901,337,180.44
51210	Өмнөх үеийн үр дүн	2,779,012,579.35	2,779,012,579.35
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	122,324,601.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	212,455,280.08	212,455,280.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,433,588,881.55</u>	<u>3,555,770,782.64</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
		/төгрөгөөр/	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,595,333,032.21	1,688,920,330.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,722,461,332.21	252,062,730.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,722,461,332.21	252,062,730.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	872,871,700.00	1,436,857,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	849,924,100.00	1,417,357,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	849,924,100.00	1,417,357,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,947,600.00	19,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,000,000.00	19,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	947,600.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	928,986,757.09	1,566,595,728.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	928,986,757.09	1,566,595,728.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	915,914,278.83	1,465,631,505.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	624,085,012.85	1,043,816,989.25
210101	Үндсэн цалин	344,264,138.92	594,855,459.35
210102	Нэмэгдэл	178,517,735.16	304,625,404.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,144,769.50	66,255,395.67
210104	Урамшуулал	66,158,369.27	78,080,730.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,224,140.89	130,366,424.06
210201	Тэтгэврийн даатгал	52,039,484.06	89,091,317.68
210202	Тэтгэмжийн даатгал	6,133,257.89	10,481,331.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,893,406.24	5,214,265.91
210204	Ажилгүйдлийн даатгал	1,196,181.19	5,115,901.93
210205	Эрүүл мэндийн даатгал	11,961,811.51	20,463,607.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,146,966.28	55,883,782.44
210301	Гэрэл, цахилгаан	5,521,383.88	6,757,292.44
210302	Түлш, халаалт	37,938,700.40	43,603,560.00
210303	Цэвэр, бохир ус	4,686,882.00	5,522,930.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,887,247.72	43,232,951.50
210401	Бичиг хэрэг	13,470,150.00	14,241,800.00
210402	Тээвэр, шатахуун	10,509,766.00	16,381,656.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,890,131.72	5,831,795.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	645,000.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,372,200.00	3,906,700.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,671,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,642,500.00	25,709,400.00
210604	Урсгал засвар	4,642,500.00	25,709,400.00
2107	Томилолт, зочны зардал	9,192,000.00	7,793,000.00
210702	Дотоод албан томилолт	9,192,000.00	7,793,000.00

Баянхонгор аймгийн Прокурорын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,195,854.00	13,432,329.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,754,700.00	12,429,830.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,070,167.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	207,996.00	334,444.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	129,991.00	624,055.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,540,557.09	145,396,628.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,859,000.00	10,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	2,024,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,681,557.09	133,272,628.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,072,478.26	100,964,223.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,800,000.00	4,620,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,800,000.00	4,620,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,272,478.26	96,344,223.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,324,878.26	96,344,223.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,666,346,275.12</u>	<u>122,324,601.09</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,333,333.28	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-7,333,333.28	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>2,659,012,941.84</u>	<u>122,324,601.09</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>872,871,700.00</u>	<u>1,438,857,600.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	2,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	2,000,000.00
120009	Бусад орлого	00.00	2,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	872,871,700.00	1,436,857,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	849,924,100.00	1,417,357,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	849,924,100.00	1,417,357,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,947,600.00	19,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,000,000.00	19,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	947,600.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>853,051,700.00</u>	<u>1,439,000,300.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	853,051,700.00	1,439,000,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	839,979,221.74	1,335,893,376.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	624,085,012.85	1,043,816,989.25

Аудитын код: БНА-2025/040/НА-СТА-ТШЗ

Хуудас-9



Баянхонгор аймгийн Прокурорын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	349,338,487.76	596,673,690.09
210102	Нэмэгдэл	179,350,154.54	303,458,170.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,676,117.60	65,604,399.07
210104	Урамшуулал	60,720,252.95	78,080,730.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,224,140.89	130,366,424.06
210201	Тэтгэврийн даатгал	52,039,484.06	89,091,317.68
210202	Тэтгэмжийн даатгал	6,133,257.89	10,481,331.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,893,406.24	5,214,265.91
210204	Ажилгүйдлийн даатгал	1,196,181.19	5,115,901.93
210205	Эрүүл мэндийн даатгал	11,961,811.51	20,463,607.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,146,966.28	55,883,782.44
210301	Гэрэл, цахилгаан	5,521,383.88	6,757,292.44
210302	Түлш, халаалт	37,938,700.40	43,603,560.00
210303	Цэвэр, бохир ус	4,686,882.00	5,522,930.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,172,747.72	40,331,451.50
210401	Бичиг хэрэг	13,177,550.00	13,406,800.00
210402	Тээвэр, шатахуун	10,509,766.00	14,991,656.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,890,131.72	5,896,295.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	645,000.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,950,300.00	4,836,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,212,500.00	14,323,400.00
210604	Урсгал засвар	11,212,500.00	14,323,400.00
2107	Томилолт, зочны зардал	9,192,000.00	7,793,000.00
210702	Дотоод албан томилолт	9,192,000.00	7,793,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,486,854.00	29,454,329.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,045,700.00	28,451,830.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,070,167.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	207,996.00	334,444.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	129,991.00	624,055.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,459,000.00	13,924,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,459,000.00	11,850,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	2,074,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,072,478.26	103,106,923.75
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	2,142,700.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	2,142,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,800,000.00	4,620,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,800,000.00	4,620,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,272,478.26	96,344,223.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,324,878.26	96,344,223.75
213304	Хөрөнгийн		

Баянхонгор аймгийн Прокурорын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>19,820,000.00</u>	<u>-142,700.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,820,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,820,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,820,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,820,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-19,820,000.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	-142,700.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,142,700.00	2,142,700.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,142,700.00	2,000,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	421,403,922.12	212,455,280.08	119,999,637.51	00.00	753,858,839.71
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	421,403,922.12	212,455,280.08	119,999,637.51	00.00	753,858,839.71
C07	Тайлант үеийн үр дүн	18,574,400.00	00.00	95,605,503.64	00.00	114,179,903.64
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	439,978,322.12	212,455,280.08	2,779,012,579.35	00.00	3,431,446,181.55
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	439,978,322.12	212,455,280.08	2,779,012,579.35	00.00	3,431,446,181.55
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	439,978,322.12	212,455,280.08	2,779,012,579.35	00.00	3,431,446,181.55
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	122,324,601.09	00.00	122,324,601.09
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	439,978,322.12	212,455,280.08	2,901,337,180.44	00.00	3,553,770,782.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,417,357,600.0	1,323,156,076.3	94,201,523.8	93.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,417,357,600.0	1,323,156,076.3	94,201,523.8	93.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,412,737,600.0	1,316,393,376.3	96,344,223.8	93.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,127,787,300.0	1,043,816,989.3	83,970,310.8	92.6
210101	Үндсэн цалин	613,476,400.0	596,673,690.1	16,802,709.9	97.3
210102	Нэмэгдэл	318,793,100.0	303,458,170.1	15,334,929.9	95.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	74,372,800.0	65,604,399.1	8,768,400.9	88.2
210104	Урамшуулал	121,145,000.0	78,080,730.0	43,064,270.0	64.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,973,300.0	130,366,424.1	10,606,875.9	92.5
210201	Тэтгэврийн даатгал	94,586,900.0	89,091,317.7	5,495,582.3	94.2
210202	Тэтгэмжийн даатгал	13,002,900.0	10,481,331.5	2,521,568.5	80.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,563,900.0	5,214,265.9	349,634.1	93.7
210204	Ажилгүйдлийн даатгал	5,563,900.0	5,115,901.9	447,998.1	91.9
210205	Эрүүл мэндийн даатгал	22,255,700.0	20,463,607.1	1,792,092.9	91.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,223,100.0	55,883,782.4	1,339,317.6	97.7
210301	Гэрэл, цахилгаан	7,705,200.0	6,757,292.4	947,907.6	87.7
210302	Түлш, халаалт	43,852,900.0	43,603,560.0	249,340.0	99.4
210303	Цэвэр, бохир ус	5,665,000.0	5,522,930.0	142,070.0	97.5
2104	Хангамж, бараа материалын зардал	40,342,400.0	40,331,451.5	10,948.5	100.0
210401	Бичиг хэрэг	12,400,000.0	13,406,800.0	-1,006,800.0	108.1
210402	Тээвэр, шатахуун	15,140,400.0	14,991,656.0	148,744.0	99.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,602,000.0	5,896,295.5	705,704.5	89.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.0	1,200,000.0	00.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.0	4,836,700.0	163,300.0	96.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,330,000.0	14,323,400.0	6,600.0	100.0
210604	Урсгал засвар	14,330,000.0	14,323,400.0	6,600.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	7,899,400.0	7,793,000.0	106,400.0	98.7
210702	Дотоод албан томилолт	7,899,400.0	7,793,000.0	106,400.0	98.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,152,100.0	9,954,329.0	197,771.0	98.1

Баянхонгор аймгийн Прокурорын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,000,000.0	8,951,830.0	48,170.0	99.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	440,000.0	334,444.0	105,556.0	76.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.0	44,000.0	44,000.0	50.0
210807	Газрын төлбөр	624,100.0	624,055.0	45.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,030,000.0	13,924,000.0	106,000.0	99.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,928,000.0	11,850,000.0	78,000.0	99.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,102,000.0	2,074,000.0	28,000.0	98.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,620,000.0	6,762,700.0	-2,142,700.0	146.4
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.0	2,142,700.0	-2,142,700.0	100.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.0	2,142,700.0	-2,142,700.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,620,000.0	4,620,000.0	00.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,620,000.0	4,620,000.0	00.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,417,357,600.0	1,321,013,376.3	96,344,223.8	93.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,417,357,600.0	1,321,013,376.3	96,344,223.8	93.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,417,357,600.0	1,321,013,376.3	96,344,223.8	93.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.0	2,142,700.0	-2,142,700.0	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.0	2,000,000.0	-2,000,000.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,500,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,500,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,000,000.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,500,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,500,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,500,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,500,000.0
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Прокурорын газар нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага.

Баянхонгор аймгийн аймгийн Прокурорын газар нь 2024 онд Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Улсын Ерөнхий Прокурорын тушаалаар баталсан хяналтын ажлын аргачилсан заавар, журмууд, Прокурорын байгууллагын 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, Улсын Ерөнхий Прокуророос өгсөн үүрэг, чиглэлийг мөрдөн шалгах болон зөрчил шалган шийдвэрлэх, ял эдлүүлэх, шүүхэд төрийг төлөөлөх ажиллагаанд болон прокурорын хяналтын ажилд нэг мөр хэрэгжүүлэх, хуулийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, хяналтын ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, прокурор ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сахилга хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагаагаа олон нийтэд ил, тод нээлттэй хүргэхэд анхаарч удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээг авч ажилласан байна.

Байгууллагын бүтэц орон тоог МУЕП-ын 2019 оны А/28 тоот тушаалаар 16 байхаар баталж өгч 2020,2021, онуудад МУЕП-ын тушаалаар орон тоог нэмэгдүүлэн ирсэн байна. Тайлант хугацаанд МУЕП-ын А/58, Б/62 дугаар тушаалаар 4 орон тоог шинээр нэмэгдүүлэн 28 алба хаагчтай үйл ажиллагаа явуулах болсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Улсын Ерөнхий Прокурорын 2016 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/28 дугаартай тушаалын хавсралтаар баталсан "Прокурорын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Прокурорын газар нь 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3 дах заасан УНББОУС-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 122,181.9 мянган төгрөг буюу 3.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Зөрүү	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	56,553.4	1.6	74,024.3	2.1	17,470.9	131
МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,142.7		2,000.0		-142.7	93
БАРАА МАТЕРИАЛ	54,410.7		72,024.3		17,613.6	132
ЭРГЭЛТИЙН ӨРӨНГИЙН ДҮН ^{БУС}	3,377,035.5	98.4	3,481,746.5	97.9	104,711.0	103
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,377,035.5		3,481,746.5		104,711.0	103
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	-208,777.4		-307,002.9		-98,225.5	147
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,433,588.9	100.0	3,555,770.8	100.0	122,181.9	103.6
НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,142.7	0.1	2,000.0	0.1	-142.7	93
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,431,446.2	99.9	3,553,770.8	99.9	122,324.6	104
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,433,588.9	100.0	3,555,770.8	100.0	122,181.9	103.6

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,000.0 мянган төгрөг байгаа нь барьцааны дансны үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 72,024.3 мянган төгрөг болж өмнөх оноос 17,613.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацаанд МУЕПГ-ын хэрэг эрхлэх газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн А/23 дугаартай тушаалаар 13,249.4 мянган төгрөгийн дүрэмт хувцас, тусгай хэрэгслийг шилжүүлэн авсан нь бараа материалын данс өсөхөд голлох нөлөө үзүүлжээ

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,481,746.5 мянган төгрөг болж 104.7 мянган төгрөгөөр өссөн байна.

2024 онд элэгдэл нь дууссан 35,047.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 745, 301 дүгээр тогтоолуудыг үндэслэн бүртгэлээс хасаж дахин үнэлгээ, ашиглах хугацааг тогтоолгон 18,675,0 мянган төгрөгөөр буцаан орлогод авсан байна.

Мөн МУЕП-ын тушаалаар доорх хөрөнгүүдийг шилжүүлэн авч орлогод авсан нь үндсэн хөрөнгийн данс өсөхөд гол нөлөө үзүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөрөнгөд авсан хөрөнгийн жагсаалт

/мянган төгрөгөөр/

Үндсэн хөрөнгийн нэр	Н.Б.Үнэ	Тоо	Дүн	Шийдвэр
Тоёота Land cruiser-300 GXR	201,200.0	1.0	201,200.0	МУЕП-ын 2024 оны А/84 дугаар тушаал
Компьютер Dell OptiPlex 7010 Dell 24 inc	3,165.8	4.0	12,663.2	МУЕП-ын 2024 оны А/116 дугаар тушаал
Тог баригч-APC Easy UPS 800Va	342.0	4.0	1,368.0	
Хүндрүүлэгчтэй сейф	1,576.9	1.0	1,576.9	МУЕП-ын 2024 оны А/165 дугаар тушаал
Мэдээллийн ухаалаг дэлгэц	2,500.0	1.0	2,500.0	МУЕП-ын 2024 оны А/184 дугаар тушаал
Нийт дүн	219,308.1			

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3.553.770.8 мянган төгрөг болж мянган төгрөг болж 122.324.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 122.324.6 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,366,404.1 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 449,074.6 мянган төгрөгөөр бууруулж 917,329.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Батлагдсан төсвийг МУЕП-ын 2024 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн А/195 дугаар тушаалаар тодотгол хийж 500,028.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,417,357.6 мянган төгрөг болгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1,417,357.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,321,013.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,321,013.4 мянган төгрөг буюу 93.2 хувьтай байгаа нь 2024 оны 4 сараас 4 орон тоо дутуу ажилласантай холбоотой цалин, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн 94,577.2 мянган төгрөг зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,412,737.6	1,316,393.4	96,344.2	93,2

2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	4,620.0	4,620.0	0.0	100.0
---	-------------------------------------	---------	---------	-----	-------

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 19,500.0 мянган төгрөг хуваарилсныг 14,000.0 мянган төгрөгийг албаны орон сууцны засварын хөлсөнд, 5,500.0 мянган төгрөгийг хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн, сургалтын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 43,852.9 мянга, гэрэл цахилгааны зардалд 7,705.2 мянга, цэвэр бохир усны зардалд 5,665.0 мянган төгрөг батлагдсанаас “РМВ” ХХК-тай дулаанаар хангах, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК,-тай цахилгаанаар хангах гэрээ, “Чандмань Баянхонгор”-тай цэвэр бохир усны гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Прокурорын газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 1/2517 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 1,417,357.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 21,260.3 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 13,819.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлын 97,7 хувь зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 20 гүйлгээний 1,364,341.7 мянган төгрөгийн мэдээллийг 100 хувь мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж аудитаар 23,900.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2024 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн 428 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	23,900.0	1	23,900.0	100%
Нийт дүн	1	23,900.0	1	23,900.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1-дүгээр батлагдсан шатахуун зарцуулалтын нормативын мөрдсөн эсэхийг анхаарч авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oO-----